Төрийн албаны зөвлөлийн
2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн
201 дугаар тогтоолын 13 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл

- [√] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- [ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
| --- | --- |
| Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газар | Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс |

| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
| --- | --- |
| Орчны эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, гэдэсний болон бэлгийн замаар дамжих халдварын тандалт сэргийлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн | Дэс түшмэл, ТЗ-5 |

| Ажлын цаг: | Ажлын байрны албан ёсны байршил: |
| --- | --- |
| Ажлын өдөр 8 цаг | Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13 дугаар баг |

| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
| --- | --- |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хууль тогтоомж, бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, орчны эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлээс шалтгаалсан өвчлөл, гэдэсний халдварт өвчин, бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулж, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж гүйцэтгэлийн үр дүнг Эрүүл мэндийн газрын даргын өмнө хариуцна.

ХУУЛБАР ҮНЭН

Албан тушаалын зорилт:

1. Орчны бохирдол, түүний шалтгаан үр дагаварыг тандах, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг бууруулах, арилгах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
2. Гэдэсний халдварт өвчин, БЗДХ/ХДХВ/ДОХ тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих.
3. Хүнсний бүтээгдэхүүний агууламжид тавих хяналтыг сайжруулж, хүнсний аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавих.
4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр<br>Туслах - Т,<br>Хариуцан гүйцэтгэх - Г<br>Хянах – Х<br>Шийдвэрлэх – Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Хүн амыг эрүүл, аюулгүй ундны усаар хангах цогц арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх; | Хэрэгжилтийн хувиар, | Т, Г |
| | 2. Орон нутагт гэр хорооллын сайжруулсан бие засах газар, бохирын цооногийг стандартын дагуу барих аргачлалыг нэвтрүүлэх; | Стандартын хэрэгжилтээр, | Г, Т |
| | 3. Хүүхдийн байгууллагын ариун цэврийн байгууламжийн дэд бүтэц, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулахад дэмжлэгт хяналт үнэлгээг хийж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах; | Дэмжлэгт хяналт үнэлгээ хийсэн байгууллагын тоогоор, | Г, Т |
| | 4. Агаар, орчны бохирдлын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрүүл мэндийн салбарын болон мэргэжлийн байгууллагууд, иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, тэдгээрийг мэргэжил арга зүйгээр хангах. | Зохион байгуулсан ажлын тоогоор, | Т, Г |
| | 5. Эрүүл мэндийн байгууллагуудын гадаад, дотоод орчинг тохижуулах, үйлчлүүлэгчид ээлтэй орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох мэргэжлийн | Тохижилтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоогоор, | Т, Г |

| | | | |
|---|---|---|---|
| | байгууллагуудтай хамтран ажиллах. | | |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1. БЗДХ/ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг авах замаар өвчлөлийг бууруулах; | Эрт илрүүлэлтийн хувиар, | Т, Г |
| | 2. Аймгийн хэмжээнд БЗДХ/ХДХВ/ДОХ-оос урьчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж, төр болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэгт хяналтыг хийж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах; | Дэмжлэгт хяналт хийсэн байгууллагын хамрагдалтын хувиар, | Т, Г |
| | 3. БЗДХ/ХДХВ/ДОХ-ын зорилтот болон эрсдэлт бүлгийн хүн амыг үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, хяналт тавих; | Үзлэг шинжилгээнд хамруулсан хүний тоогоор, | Т, Г |
| | 4. БЗДХ/ДХВ/ДОХ-ын аймгийн хэмжээний тоон тайланг нэгтгэн дүгнэлт өгч, БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг эргэн мэдээллээр ханган ажиллах; | Мэдээлэл, зөвлөмжийн хэрэгжилтийн хувиар, | Т, Г |
| | 5. Гэдэсний халдварт өвчинтэй холбоотой мэдээ тайланг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудыг мэдээ, мэдээллээр ханган мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах. | Мэдээлэл, зөвлөмжийн хэрэгжилтийн хувиар, | Г, Т |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1. Олон нийтэд зориулсан МСС-ны материал боловсруулах, түгээх, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, үйл ажиллагааг сурталчилах ажлыг олон талт хэлбэрээр зохион байгуулах; | Зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүнгээр, | Т, Г |
| | 2. Орон нутгийн хүн амын хүнсний баталгаат байдлын талаарх мэдлэг, хандлага, дадлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх; | Хүнсний аюулгүй байдал хангагдсан байна. | Т, Г |
| | 3. Орон нутгийн хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөж буй стандартын хэрэглээ, хэрэгжилтийн байдалд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавих, зөвлөгөө | Хяналтаар илэрсэн зөрчлийг арилгасан байна. | Т, Г |

МОНГОЛ УЛС ... ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | өгөх; | | |
| | 4. Баталгаатай хүнс сонгох, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг зөв бэлтгэх, боловсруулах, үйлдвэрлэх, хадгалах талаар нийтийн хоолны үйлчилгээ, хүнсний худалдаа эрхлэгчид, сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол тэжээл бэлтгэн нийлүүлэгчдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт явуулах; | Зохион байгуулсан сургалт, хамруулсан худалдаа эрхлэгчдийн тоогоор, | Т, Г |
| | 5. Орон нутагт гарч буй хоол хүнсээр дамжих өвчний тархалт, хөдлөл зүй, шалтгааныг судалж, өвчлөлийг бууруулах, таслан зогсоох үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх; | Голомтыг таслан зогсоон хоол хүнсээр дамжих халдварын дэгдэлтий бууруулсан тоогоор, | Т, Г |
| | 6. Орон нутгийн хүн амын хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүний чанар, баталгаат байдалд холбогдох байгууллагуудтай хамтран тандалт, судалгаа, эрсдлийн үнэлгээ хийх; | Тандалт, судалгаа, үнэлгээ хийсэн байгууллагын тоогоор, | Т, Г |
| | 7. Орон нутгийн хүн амын хүнсний баталгаат байдлын талаарх мэдлэг, хандлага, дадлыг судлах, нотолгоонд тулгуурласан арга хэмжээ авч хэрэгжүүлэх. | Мэдлэг, хандлага, дадлын түвшин, эзлэх хувиар, | Т, Г |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1. Эрх бүхий албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх; | Үүрэг даалгаврын хэрэгжилтээр, | Г |
| | 2. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, журмыг мөрдөж ажиллах; | Стандартыг мөрдөж ажилласан байна. | Г |
| | 3. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох; | Оролцсон арга хэмжээний тоогоор, | Г |
| | 4. Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чандлан мөрдөж, Авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах; | Ёс зүйн зөрчил дутагдалгүй ажилласан байна. | Г |
| | 5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангаж ажиллах; | Зөрчилгүй байна. | Г |
| | 6. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлж ажлын | Хэрэгжилтийн хувиар, | Г |

МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | гүйцэтгэл, үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцан ажиллах. | | |

| III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | | |
|---|---|---|
| Боловсрол | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй. | |
| Мэргэжил | Эрүүл мэнд /091/. | |
| Мэргэшил | Төрийн албаны мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх. | |
| Туршлага | Төрийн албанд 2-оос доошгүй жил ажилласан байх. | |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;<br>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх;<br>- нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах;<br>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;<br>- бусад. |
| | Асуудал шийдвэрлэх | - Үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх;<br>- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах;<br>- шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх;<br>- өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх;<br>- аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх;<br>- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих;<br>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх;<br>- хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;<br>- бүтээлч, санаачилгатай ажиллах;<br>- бусад. |
| | Багаар ажиллах | - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;<br>- багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх;<br>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;<br>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;<br>- хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх;<br>- нээлттэй, шударга байх;<br>- бусад. |
| | Бусад | - өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх,<br>- зарчимч, тууштай, ажил хэрэгч байх;<br>- шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх;<br>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;<br>- албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;<br>- компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;<br>- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх;<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай |

| | | |
|---|---|---|
| | | байх. |

## IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Эрүүл мэндийн газрын дарга

| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект : |
|---|---|
| Байхгүй. | - Эрүүл мэндийн яам, агентлагийн холбогдох мэргэжилтэн,<br>- Аймгийн Засаг даргын орлогч,<br>- Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга, мэргэжилтнүүд,<br>- Эрүүл мэндийн салбарын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд,<br>- Иргэн, хуулийн этгээд. |

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
|---|---|
| Албан тушаал:<br>ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН УДИРДЛАГА ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА<br>........................................ Н.ОЮУНТУЯА<br>20.... оны ..... дугаар сарын .....-ны өдөр | Байгууллагын нэр:<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br>Шийдвэрийн огноо: ...19...10...30<br>Дугаар: ........201............ |

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр:

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо: ...............

Дугаар: ........................

(тамга/тэмдэг)

ДАРГА ............................................ Д.ШИВААННҮРДЭВ

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр